



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/80

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын уламжлалт сар шинийн баяр, амралтын өдрүүдийг тохиолдуулан Гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллах хугацаанд Хэрлэн сумаас орох, гарах хөдөлгөөнийг бүсчлэн хаах хяналтын 11 цэгт 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл 6 хоногийн хугацаанд ажиллах 23 алба хаагчдын хоол, 11 автомашины шатах тослох материалын зардлыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 4.806.000 /дөрвөн сая найман зуун зургаан мянга/ төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010223

02 Аймгийн Засаг даргын 2021 оны
... дугаар сарын ... өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

Байгууллагын нэр	Зардлын нэр төрөл		Дүн
	Шатахууны зардал	Хоолны зардал	
Цагдаагийн газар	2046000	2760000	4806000
Дүн	2046000	2760000	4806000